

**ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ҮЙЛЭЭС НЭР ҮГ БҮТЭЭХ  
“-ДАЛ” ДАГАВАР БА ОЙРОЛЦОО ДАГАВАРЫН ТУХАЙ**

**Б. Мөнгөнцэцэг \***

Монгол үгийн дагавар бүтээвэр бол үгийн язгуур ба үндсийн дараа шууд байрлан, үгэнд цоо шинэ утга оруулж, үгийн сангийн нэгж бүтээдэг залгавар бүтээвэр юм. Үгийн язгуур, дагавар нь харилцан шүтэлцээтэй бөгөөд “үгийн дагавар нь язгуураасаа ангид ямар ч утга илтгэсэн дохио болж чадахгүй, үүнчлэн үгийн цэвэр язгуур нь дагавраасаа ангид тодорхой утгатай дохио болж чадахгүй юм<sup>1</sup>”.

Энэ тухайд эрдэмтэн Ж.Баянсан “Дагавар бүтээврийн утга нь язгуурын утгыг бодвол илүү хийсвэр шинжтэй байдаг. Ийм учраас дагаврын утгыг тодорхойлохдоо тухайн дагаврыг залгаж байгаа үгийн үгсийн сан- утга зүйн шинжийг бас анхаарах нь зүйтэй”<sup>2</sup> гэжээ.

Бид энд монгол хэлнээ түгээмэл хэрэглэгддэг бүтээлч дагаврын нэг болох үйл үгээс нэр үг үүсгэдэг “-дал” дагаврыг сонгон авч, утга зүйн шинжийг авч үзэхдээ уг дагаврыг залгахад илрэх утга нь холбогдож байгаа үгсийн үгийн сан- утга зүйтэй ямар холбоо хамааралтай байгааг тодруулахын зэрэгцээ бусад дагаврын утгатай харьцуулан, ойролцоо утга илтгэх чадамжийг ажиглаж үзсэн юм.

Юуны өмнө уг дагаврыг үйл үндсэнд залгахад илрэх утгын талаар монгол хэл зүйн судалгааны зарим бүтээлд тодорхойлсон байдлыг авч үзье.

---

\* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Хэл шинжлэлийн тэнхим

<sup>1</sup>) Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц, Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь, Уб., 1968, 101 т.

<sup>2</sup>) Ж.Баянсан. Монгол хэлний нэгэн дагавар бүтээврийн утга зүйн асуудалд// МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, №3 (83), Уб., 1983, 114

1		үйлийн үр дүн	үйлийн явц	үйлийн байлал	үйлийн болох	үйлийн багаж	үйлийн дүнд бүтсэн	үйлийн арга	үйлийн гүйцэтг
		1	2	3	4	5	6	7	8
1.	Ц.Өлзийхутаг <sup>3</sup>	+		+					
2.	П.Бямбасан <sup>4</sup>	+	+		+				
3.	ОЦМХЗүй <sup>5</sup>	+	+		+				
4.	Цэнгэлтэй <sup>6</sup>	+			+	+			
5.	Л.Болд <sup>7</sup>	+	+		+				+
6.	У.Ж.Дондуков <sup>8</sup>	+			+				
7.	С.Галсан <sup>9</sup>	+		+					
8.	Б.Х.Тодаева <sup>10</sup>	+	+						
9.	ОЦМХ <sup>11</sup>	+	+			+			
10.	Ш.Лувсанвандан <sup>12</sup>	+							
11.	В.Котвич	+							
12.	А.Д.Руднев <sup>13</sup>	+		+				+	
13.	Н.Поппе <sup>14</sup>	+							
14.	Д.Бадамдорж <sup>15</sup>	+							
15.	МХХХЗ <sup>16</sup>		+				+		
16.	Хас-Эрдэнэ, Наранбат <sup>17</sup>				+				
17.	О.Ковалевский <sup>18</sup>					+			
18.	Ц.Цэцэнцогт <sup>19</sup>	+	+			+	+		

<sup>3)</sup> Ц.Өлзийхутаг. Монгол хэлний үгийн бүтэц, түүнийг дунд сургуульд заах тухай, Уб., 1967, 132

<sup>4)</sup> П.Бямбасан. Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг. Уб., 1975, 31, 32

<sup>5)</sup> Орчин цагийн монгол хэлний зүй. Уб., 1966, 82

<sup>6)</sup> Цэнгэлтэй. Одоо үеийн монгол хэлний зүй. Хөх хот, 1984, 547

<sup>7)</sup> Л.Болд. Орчин цагийн монгол хэлний дагавар. Уб., 1986, 67-68

<sup>8)</sup> У.Ж.Дондуков. Словообразование монгольских языков, Улан- Үдэ, 1993, 61

<sup>9)</sup> С.Галсан. Сопоставительная грамматика русского и монгольского языка, Уб., 1975, 149

<sup>10)</sup> Б.Х.Тодаева. Грамматика современного монгольского языка, М., 1951, 53

<sup>11)</sup> Орчин цагийн монгол хэл. Уб., 1997, 182, 183

<sup>12)</sup> Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц, Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь, Уб., 1968, 101 т.

<sup>13)</sup> А.Д.Руднев. Лекции по грамматике монгольского письменного языка, Санкт Петербург, 1905, 56

<sup>14)</sup> Н.Поппе. Грамматика письменно- монгольского языка, М., 1937, 100

<sup>15)</sup> Д.Бадамдорж. Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс, Уб., 1997, 147

<sup>16)</sup> Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй, Уб., 1985, 86


<sup>17)</sup> Хас-Эрдэнэ, Наранбат. Монгол хэлний үндэс, Хянган, 1978, 134

<sup>18)</sup> О.Ковалевский. Краткая грамматика монгольского книжного языка, Казань, 1835, 35

<sup>19)</sup> Ш.Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь. Жанг Жияя Кеу, 1988, 2797

Эдгээр тодорхойлолтоос “-дал (-дэл, -дол, -дөл)” дагаврыг залгаж үйл үгээс нэр үг үүсгэхэд илрэх утга нь чухам ямар үндсэнд залгаснаас хамаарч өөр өөр байгааг ямар нэг хэмжээгээр тусгасан болох нь харагдаж байгаа хэдий ч уг дагаврыг тусгайлан нарийвчилж судалсан зүйл ховор байна.

“-дал (-дэл, -дол, -дөл)” дагаврыг залгаж үйл үгээс нэр үг үүсгэхэд илрэх утгыг нэг талаас, бодит юм үзэгдэлтэй шууд холбоо бүхий юмжуулах харьцаа (денотативное отношение), нөгөө талаас, юм үзэгдэлтэй шууд холбоогүй, харин юмын шинж чанар, хөдөлгөөнтэй холбоотой дохиожуулах харьцаа (сигнификативное отношение)-ны үүднээс ялган үзэж болмоор байна. Тодруулбал, бодит буюу юмжуулах харьцааны үүднээс, юмыг заасан бол тухайн үйлийн болох орон болоод үр дүнг, харин хийсвэр буюу дохиожуулах харьцааны үүднээс, юмыг заагаагүй бол тухайн үйлийн дүр байдлыг илтгэх утга илэрч байна.



Одоо уг дагавраар илрэх утга нь чухам ямар үндсэнд залгаснаас хамаарч өөр өөр байгааг харьцуулан авч үзье.

1. а. Нэр үг үүсгэх “-дал” дагаврыг өөрийн эрхээр шилжин хөдлөх утга бүхий “яв-, алх-, гишгэ-, гүй-, нүү-, буу-, зөө-” зэрэг үйл үндсэнд залгахад уг үйлийн дүр байдлын утга илэрнэ гэж үзэж болмоор байна. Жишээлбэл:

яв- (хүн, амьтны алхах, зорчих, одох) →	явдал (1.явах үйлийн нэр, 2.морь малын жороо, сайвар, хатир зэрэг гүйдэл, алхаа)
алх- (нэг нэгэн алхмаар урагшлан явах) →	алхдал (алхах янз байдал <sup>20</sup> , алхаа, явдал)
гишгэ- (1.юмыг хөлийн улаар дарах, 2.алхах) →	гишгэдэл (морь малын явдал гишгэлт)
гүй- (хүн, амьтны түргэвчлэн харайн явах) →	гүйдэл (гүйх үйлийн нэр, гүйх явдал)
нүү- (нэг нутгаас нөгөөд шилжин буухаар нүүдэл хийх) →	нүүдэл (нутаг сонгож, нэг газраас нөгөөд шилжин явах, байр бууцаа солих нь)
буу- <sup>21</sup> (дээрээс доошлох, уруудах, доош шилжих) →	буудал (аян нүүдлийн зам зуур буух явдал <sup>22</sup> )

<sup>20)</sup> Ц.Норжин, М.Мөрөн. Монгол хэлний толь, Хөх хот, 1999, 79

<sup>21)</sup> “буу-” гэсэн үйл үндэс нь “5. түр болон удаан хугацаагаар орших, нутаглах” гэсэн утга илтгэж байгаа тохиолдолд “-дал” дагавраар үүссэн нэр болох буудал (1.явуулын хүний буух, амрах, хоноглох байрлах газар, 2. өртөө зогсоол, 3. бууц, буурь, 4. хуаран, хүрээ) нь үйлийн болох орны утгыг илтгэж байна.

зөө- (хүн, амьтан ямар нэг юмыг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн хүргэх) →	зөөдөл (юм хумыг нааш цааш авч явах ажиллагаа <sup>23</sup> )
--	---

б. Өөрийн эрхээр шилжилгүй хөдлөх утга бүхий “суу-” (бөгсөөрөө юман дээр тулж байх) гэсэн үйл үндсээс “-дал” дагавраар үүссэн нэр болох “суудал” нь “1.суух явдал<sup>24</sup>” гэсэн утга илтгэвэл уг үйлийн дүр байдлыг, харин “2.суух ор байр буюу сандал” гэсэн утга илтгэвэл үйлийн болох орны утгыг илтгэж байна.

Мөн өөрийн эрхээр шилжилгүй хөдлөх утга бүхий бай- (орших, нутаглах, суух) үйл үндсээс уг дагавраар үүссэн нэр болох “байдал” (1.хүн амьтан ба юмны гадар дүрс, хэлбэр маяг; 2.хэрэг учир буюу цаг үеийн хувиралтын төлөв; 3.хүний зан авир, санаа бодлын шинж төлөв<sup>25</sup>) нь юмыг заагаагүй тул уг үйлийн дүр байдлыг илтгэнэ.

в. Өөрийн эрхгүй хөдлөх утга бүхий “мох-” (1.ир нь муудах; 2.шилж. халирах, шантрах) гэсэн үйл үндсийн шилжсэн утгаас “-дал” дагавраар үүссэн мохдол (мохох явдал) нь уг үйлийн дүр байдлыг зааж байгаа бол “үх-” (амьд биеийн амь тасрах, үгүй болох) гэсэн үйл үндсээс үүссэн “үхдэл” (үхсэн хүн, хүүр) нь юмыг зааж буй тул уг үйлийн үр дүнг заасан утга илтгэж байна.

Эдгээр үгс бол үгсийн сангийн утгаараа ялгарч хэдийгээр өөр өөр үйлийг илтгэж байгаа боловч өөрийн эрхээр болон өөрийн эрхгүй хөдлөх утга илтгэх утга зүйн шинжээрээ нэгэн бүлэг болон нэгдсэн үгс юм.

2. а. Оё-, наа-, зүй-, боо-, барь-, ороо-, хий-, гуй- зэрэг бие болоод хэлээр бүтээн хөдлөх утга бүхий үйл үгэнд нэр үг бүтээх “-дал” дагавар залгахад тухайн үйлийн дүр байдлыг илтгэх утга илэрнэ. Жишээ нь:

Биеэр бүтээн хөдлөх утга бүхий	оё- (бөс давуу, арьс зэрэг эдлэлийг зүүгээр сүлбэн утсаар бэхлэн тогтоож ямар нэг зүйл хийх) →	оёдол (1.оёх үйлийн нэр, 2. юмны оёсон газар, оёо, оёос)
	наа- (юмыг өөр хооронд нь барьцалдуулан тогтоох) →	наадал (наасан хэсэг, наалт)
	зүй- (жигжиг хэсэг юмыг нийлүүлэн холбох, наах, оёх, хадах зэргээр эвлүүлэх) →	зүйдэл (1.зүйсэн хэсэг, зүйх юм, 2.эд юмын зүйсэн уулзвар, оёдол, 3.зүйж оруулах, залгахаар бэлтгэсэн юм)
	боо- (1.цуглах, хуйлах, баглах; 2.уях, хүлэх, зангидах тогтоох) →	боодол (хэсэглэн боосон, багласан зүйл)
	барь- (аливаа юмыг гартаа атгах, хөтлөх) →	барьдал (барьц)
	ороо- (тойруулан боох) →	ороодол (ороосон янз байдал)
	хий- (үйлдэх, бүтээх) →	хийдэл (1.юмыг үйлдэж бүтээх явдал, 2.бөхийн мэх <sup>26</sup> )
шүү- (яриа тоглоом наадам, тэмцээнд хожих, дийлэх, ялах) →	шүүдэл (хуучирсан мөрийний хожил)	

<sup>22)</sup> Ц.Норжин, М.Мөрөн. Монгол хэлний толь, Хөх хот, 1999, 887

<sup>23)</sup> Д.Баатар. Монгол хэлний үүсмэл үгийн тонгоруу толь, Хөх хот, 1988, 1800

<sup>24)</sup> Ц.Норжин, М.Мөрөн. Монгол хэлний толь, Хөх хот, 1999, 1931

<sup>25)</sup> Ц.Норжин, М.Мөрөн. Монгол хэлний толь, Хөх хот, 1999, 866 т.

<sup>26)</sup> Д.Баатар. Монгол хэлний үүсмэл үгийн тонгоруу толь, Хөх хот, 1988, 1799

Хэлээр бүтээн хөдлөх утга бүхий	гуй- (бусдад юм авах хүслээ илэрхийлэн эрэх хүсэх) →	гуйдал (гуйх явдал)
	асуу- (1.ямар нэг зүйлийг мэдэх, сонсох зорилгоор лавлах, сураглах) →	асуудал (1.судлах, шийдвэрлэвэл зохих зүйл, ажил хэрэгч санаа, 2.асуулт)

б. Бие, хэлээр бүтээн хөдлөх утга бүхий заа-, өргө-, шүү-, зар-, захь-, асуу-, орго- зэрэг үйл үгэнд нэр үг бүтээх “-дал” дагавар залгахад тухайн үйлийн үр дүнг илтгэх утга илэрнэ. Үүнд:

Биеэр бүтээн хөдлөх утга бүхий	заа- (юманд заадал, заадас гарган залгах, зүйх) →	заадал (хоёр юмны уулзварыг нийлүүлэхэд харилцан салаавчилж бие биедээ зууж бэхлэгдсэн хэсэг, углуурга)
	өргө- (2.өгөхийн хүндэтгэл, өргөмжлөх) →	өргөдөл (дээд тушаалын хүмүүст хандаж эрэлт хүсэлтээ гаргасан мэдүүлэх бичиг)
	зар- (4.юмыг эдэлж хэрэглэх) →	зардал (1.зарж хэрэглэх мөнгө төгрөг, эд юм, 2.хэрэгцээ)
	орго- (босох, буруулан зайлж одох, нуугдан дугаах) →	оргодол (ял шийтгэлээс дутаасан хүн)
Хэлээр бүтээн хөдлөх утга бүхий	захи- (1.хүнд эрхбиш чухал хэрэгтэй гэсэн зүйлийн талаар сануулан хэлэх, урьдчилан анхааруулах, сургаж зааварлах, 2.бусдад хэл захиа өгөх) →	захидал (албан газар, хүмүүсийн хоорондын харилцааны бичиг захиа)

Эдгээр үгс бол бие болоод хэлээр бүтээн хөдлөх үйлийг заасан үгсийн сан- утга зүйн ерөнхий утгаараа нэгдэж нэгэн бүлэг болж буй үгс юм.

Ийнхүү дагаврын утга нь зохих үгтэйгээ холбогдсон тохиолдолд илүү тодорхой болохоос гадна бид одоо үйлээс нэр үг үүсгэх “-дал” дагавар нь ямар ямар дагавартай зэрэгцэн ижилсэж, ойролцоо үг бүтээх чадамжтай болохыг тодруулъя.

Н.Б.Дугаров буриад хэлнээ ойролцоо утгатай дагавруудыг нэг язгуурт залгаж, ойролцоо үг бүтээх нь элбэг ба эдгээр нь утгаараа нэн ойр, ихэвчлэн найруулгын өнгө аясыг ялгадаг<sup>27</sup> гээд,

-*lya-lta* (бусаалга-бусаалта, заналга-заналта, золголго-золголто)

-*l-lang* (жаргал-жаргалан, хүсэл-хүслэн)

-*lta-buri* (сасуулалта-сасуулбари, жэшиээлэлтэ-жэшиээлбэри)

-*lya-buri* (заһалга-заһабари, түлэлгэ-түлбэри)

-*liy-rqai* (уһалиг-уһархуу, гүбээлиг-гүбээрхүү, хадалиг-хадархуу)

-*rqay-rqai* (хадархаг-хадархуу, загаһархаг-загаһархуу, чамуурхаг- чамуурхуу)

-*tai-rqai* (бараатай-бараархуу, томоотой-томоорхуу, нюргатай-нюргархуу)

-*mar-maqai* (эдимэр-эдимхэй, уумар-уумхай)


-*na-si* (саана-сааша, наана-нааша)

<sup>27)</sup> Н.Б.Дугаров. Лексические синонимы в современном бурятском литературном языке. М., 1978, 25

–*daki-duyār* (нэгэдэхү-нэгэдүгээр)

–*btur-siy* (хүхэбтэр-хүхэшиэг, улаабтар-улаашиаг, гашуубтар-гашуушаг) зэрэг ойролцоо дагаврыг жагсаасан бол Т.Н.Павлов “Ойролцоо утгатай бүтээвэр нь өөр хоорондоо бүрэн тохирохын зэрэгцээ заримдаа эргэлзээтэй байдаг ч тэдгээрийн утгаараа ялгарах нь янз бүр байдаг ойролцоо утгын нэгэн хэв маяг болдог. Ойролцоо утгат дагавар нь тухайн эхийн дотор харилцан сольж болох, утгаараа адил өөр дагаврууд байдаг”<sup>28</sup> гэжээ. Академич Ш.Лувсанвандан “Үгийн салбар олон утгатай байдаг учир үүнд холбогдон утга харилцан ойр байх явдал дан ганц үгийн гол утгаар илрэлээ олох бус мөн үгийн салбар утгад холбогдож болно”<sup>29</sup> гэсэн бөгөөд энэ тухайд Ю.Д.Апресян “Эцсийн эцэст, салаа утга, ойролцоо утга хоёр нь хам цагийн үүднээс ч нарийн холбоотой юм. Олон утгат үг уг ёсоороо хэд хэдэн ойролцоо үгийн үүр эгнээнд ордог. Үүнийг тэмдгээр илэрхийлбэл тохиромжтой юм. Хэрэв “А” гэдэг үг нь а, б, в, г гэсэн салаа утгатай бол А, Б, В, Г гэсэн ойролцоо үгийн эгнээнд “а” орж болно. “б” нь А, Л, М, Н-д, “в” нь А, О, П, Р-д тус тус орж болно. Тэгвэл Б, В, Л, М, О, П нь мөн л олон утгатай болно”<sup>30</sup> гэж үзсэн байна.

А. “1.бөс даавуу, арьс зэрэг эдлэлийг зүүгээр сүлбэн утсаар бэхлэн тогтоож ямар нэг зүйл хийх: оёх хатгах, оёх шидэх, оёх эсгэх, 2. мäs ажилбарын дараа эсгэж зүссэн махбодыг нийлүүлэн бэхлэх” гэсэн утга бүхий оё- үйл язгуураас



гэх мэтчилэн төрөл үг үүсэх бөгөөд оёдол нь “1.оёх үйлийн нэр, 2.юмны оёсон газар, оёо, оёос” гэсэн салаа утгатайгаас 2-р утга нь “оёо” гэсэн үгтэй утга ойролцоо болох хэдий ч “оёдол” нь хонин холбоо, зүү ороох зэргээр ерөнхий оёх үйлийн дүр байдлыг, “оёо” нь оёсон байдал, янз маяг (шинж чанар)-ыг илтгэх утгын нарийн ялгамжтай бол “оёос” нь оёсон газар, оёдлын ормыг хэлж байна. Түүнчлэн “оёоч, оёгч” нь “оёж хатгадаг хүн” гэсэн утгатай боловч “оёдол хийхдээ дадамгай, сайн” нь “оёоч” болно. Ийхүү нэг язгуураас дагаврын аргаар бүтсэн үгсийн дагавар нь өөр дагавартай тэнцүү утгатайн зэрэгцээ хоорондоо ижилсэж, бие даасан ойролцоо үг бүтээхийг ойролцоо ба төсөөт үгийн дундын буюу хоёрдмол шинжтэй гэж үзэж болно. Харин нэг (оё-) язгуурт орсон угсарсан дагавар нь ижилссэн бол төсөөт үг (оё-дол-ч(ин); оё- дол- т) болно.

<sup>28)</sup> Т.Н. Павлов. Разновременная словообразовательная синонимия в древнерусских житиях. *Нейдәи ііа е әйәйдәи ііа а үсүеә е дә-е.*(Материалы международной научной конференций. Иркутск, 10-13 сентября 2000 года). Иркутск, 2007, 89

<sup>29)</sup> Ш. Лувсанвандан. Үгсийн сангийн зүй. Бээжин, 1962, 45

<sup>30)</sup> Ю.Д. Апресян. Проблема синонима. *Айи дйиу үсүейсй ай еү*, №6. М., 1957, 85

зүй- (жигжиг хэсэг юмыг нийлүүлэн холбох, наах, оёх, хадах зэргээр эвлүүлэх) →

*зүйдэл*

1. зүйсэн хэсэг, зүйх юм
2. эд юмын зүйсэн уулзвар, оёдол
3. зүйж оруулах, залгахаар бэлтгэсэн юм

*зүйдэс*

1. зүйж оёсон хэсэг
2. зүйж оруулсан юм, зүйсэн хэсэг

заа- (юманд заадал, заадас гарган залгах, зүйх) →

*заадал*

1. хоёр юмны уулзварыг нийлүүлэхэд харилцан салаавчилж бие биедээ зууж бэхлэгдсэн хэсэг, уулзвар, ам, тээг, углуурга
2. тэнгэрийн оёор хэмээх сансрын мананцар: тэнгэрийн заадал (тэнгэрийн оёдол, сүүн зам)

*заадас*

1. хүн, амьтны гавлын ясны уулзвар
2. хоёроос дээш нийлсэн юмны уулзвар, зааг нийлсэн газар: тэнгэрийн заадас
3. модон эдлэл, сав суулганы хэсгүүд нийлсэн хэсэг; углуурга, ам, зааг
4. нумын хоёр үзүүрийн хөвчтэй уулзсан хэсгийг торгох тэвх

гишгэ- (1. юмыг хөлийн улаар дарах; 2. алхах) →

*гишгэдэл*

морь малын явдал гишгэлт

*гишгэц*

1. гүехэн ус, шавар шалбаагтай газарт алхам тутамд тохируулан тавьсан чулуу
2. гишгэдэл
3. шүлгийн хэмнэл
4. дууны нотны цохилго, айзам

асуу-(ямар нэг зүйлийг мэдэх, сонсох зорилгоор лавлах, сураглах) →

*асуудал*

1. судлах шийдвэрлэвэл зохих зүйл, ажил хэрэгч санаа
2. асуулт

*асуулт*

1. тайлбар, хариу хүсч хандсан нь
2. шийдвэрлэвэл зохих зүйл буюу асуудал
3. шалгалт шүүлэг өгч буй хүнээс хариу авч үнэлэлт өгөхөд зориулж асуух зүйл

Толь бичигт “буудал (явуулын хүний буух, амрах, хоноглох, байрлах газар)” хэмээх үг нь 1. өртөө, зогсоол; 2. бууц, буурь; 3. хуаран, хүрээ гэсэн салаа утгатайгаас 2 дахь утга нь “бууц, буурь” гэсэн үгтэй ойролцоо утга илтгэх бөгөөд буурь нь “нэлээд эртний буюу бүдгэрч эдгэсэн ором”, бууц нь “тов тодорхой буюу нүүгээд удаагүй үлдсэн ор мөр, ором” гэсэн утгын нарийн ялгамжтай. Түүнчлэн *захидал* (албан газар, хүмүүсийн хоорондын харилцааны бичиг захиа) ~ *захиа* (хүмүүсийн хоорондоо харилцан илгээх бичиг; захидал); *барьдал* (барьц) ~ *барьц* (бөхийн барих газар) зэргээс гадна нэг язгуураас үүссэн ойролцоо үгс нь найруулгын ялгаатай байх нь бий. Тухайлбал: наа- (юмыг өөр хооронд нь барьцалдуулан тогтоох) → наадал<sub>яриа</sub> ~ наалт (наасан хэсэг); алхдал<sub>яриа</sub> ~ алхаа (явах үеийн хөлийн хөдөлгөөний хэв маяг, явдал, алхаш, алхам) г.м.

Ойролцоо дагавар бүхий үгс нь (нэг язгуураас үүссэн ойролцоо үгс) нь тухайн эхэд нэгийг нөгөөгөөр солин найруулах боломжтой байна. Жишээ нь: *Монгол хүн буудал /бууцан/ буурин дээрээ гурван жилийн хоол хаяад нүүдэг* (Ж.Пүрэв, Гурван зангилаа). *Амгалан сайн багшийнхаа ачаар савхин эдлэлийн нарийн оёдол/ оёо сурсаар л байлаа* (Г.Жамъян, Гал атгасан гар).

Эцэст нь дүгнэхэд, монгол хэлний үйл үгээс нэр үг үүсгэдэг –дал дагаврын утга зүйн шинжийг авч үзэхэд уг дагаврыг залгахад илрэх утга нь холбогдож байгаа үгсийн үгийн сан- утга зүйтэй холбоо хамааралтай байна. Тодруулбал, уг дагаврыг өөрийн эрхээр шилжих болон шилжилгүй хөдлөх утга бүхий үйл үндсэнд залгахад уг үйлийн дүр байдлыг заасан утга илрэх бол, өөрийн эрхгүй хөдлөх утга бүхий үйл үндсэнд залгахад юмыг зааж, улмаар уг үйлийн үр дүнг заасан утга цөөн боловч илэрч байна. Түүнчлэн бие, хэлээр бүтээн хөдлөх утга бүхий үйл үндсэнд залгахад юмыг заасан эсэхээс хамаарч, тухайн үйлийн дүр байдал болон үр дүнг илтгэх утга илэрнэ гэж үзэж болмоор байна.

Монгол хэлний үйл үгээс нэр үг үүсгэдэг -дал дагавар нь -ц, -рь, -аа, -лт, -дас зэрэг дагавартай тэнцүү утгатай байж, ойролцоо утга илтгэх чадамжтай болох нь хэлний баримтаас харагдаж байна. Энэ нь өөр өөр дагавар утгын хувьд ойртож ойролцоо утга илтгэснээс үүсч байна.

## SUMMARY

Considering the characteristic according to meaning of Mongolian suffix “-дал” forms the noun from the verb, the words can be related with the vocabulary and meaning of the words it’s meaning. To clarify, when make affixation to the verb root which has the changeable and not changeable meaning it’s meaning changed into the appearance of the action, but if make affixation to the changeable root it’s changed into the things and also the few meaning that includes the result of the action. Also during the affixation of the body and language actions depending on whether they demonstrating the things, it can be considered that it will show the result of the appearance or the actions.

Mongolian suffix “-дал” is equivalent with the -ц, -рь, -аа, -лт, -дас in meaning and in language fact it is able to express synonym in meaning. It was formed as it can have similar meaning according to the different suffix and meaning.